



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН
ДААТГАЛЫН ТӨСӨЛ



МАЛЫН ЭРСДЭЛИЙН ДААТГАЛЫН 2011 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТАЙЛАН

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

УЛААНБААТАР ХОТ
2011 он



Агуулга

I.	МЭД-ын 2011 оны борлуулалтын улиралд хийж гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт.....	3
II.	МЭД-ын 2011 оны борлуулалт.....	5
	• Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгуудын 2011 оны борлуулалтын үр дүн.....	9
	• 2010 онд МИД төсөлд хамрагдсан Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймгуудын борлуулалтын үр дүн	12
	• 2011 онд МИД төсөлд шинээр хамрагдсан Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудын борлуулалтын үр дүн.....	15
III.	Даатгалын компанийн борлуулалтын үр дүн	18
IV.	МЭД-ын хураамжийн зээл.....	22
	Дүгнэлт.....	24



Хүснэгт, графикийн товчоо

Хүснэгт №1. МЭД-ын 2011 борлуулалтын улирлын үйл явц.....	3
Хүснэгт №2. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо, хураамжийн хэмжээ, 2011 он.....	6
Хүснэгт №3. МЭД-д хамрагдсан малын тоо(малын төрөл, аймгаар).....	7
Хүснэгт №4. Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо, хураамжийн орлого болон нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн(2011 он, аймгаар).....	8
Хүснэгт №5. Даатгуулсан малчин өрхийн тоо, МДНТД-нд хуримтлуулсан хураамжийн орлогын 2010 оны борлуулалттай харьцуулсан дүн (Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймаг).....	10
Хүснэгт №6. Даатгуулсан малчин өрхийн тоо, МДНТД-нд хуримтлуулсан хураамжийн орлогын 2010 оны борлуулалттай харьцуулсан дүн (Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймаг).....	12
Хүснэгт №7. Даатгуулсан малчин өрхийн тоо ба МДНТД-нд хуримтлуулсан хураамжийн орлогын дүнд эзлэх хувь (Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймаг).....	15
Хүснэгт №8. Даатгалын компаниудын борлуулалтын тоо, хураамжийн орлогын дүн (аймаг, даатгалын компаниар, 2011 он)	18
Хүснэгт №9. Даатгуулсан малчин өрхийн тоо ба хураамжийн орлогын 2010 оны борлуулалттай харьцуулсан дүн (даатгалын компаниар).....	19
Хүснэгт №10. Борлуулалт хийсэн болон огт борлуулалт хийгээгүй төлөөлөгчдийн тоо (аймаг, даатгалын компаниар).....	20
Хүснэгт №11. Даатгуулсан малчин өрхийн тоо, дүнд эзлэх хувь, даатгалын компаниар.....	21
Хүснэгт №12. МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо.....	22
Хүснэгт №13. МЭД-ын хураамжийн зээлийн хэмжээ.....	22
Хүснэгт №14. МЭД-ын хураамжийн зээлийн дундаж.....	23
 График №1. МЭД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо.....	5
График №2. МЭД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/.....	6
График №3. Аймгийн малчин өрхөд МЭД-д даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь.....	7
Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгуудын борлуулалтын үр дүн	
График №4. МЭД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо (2006 – 2011 он).....	9
График №5. МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоо(даатгалын компани, аймгаар, 2011 он).....	9
График №6. МДНТД-нд төвлөрүүлсэн хураамжийн орлого 2006–2011он (сая төг.өөр).....	10
График №7. МЭД-д даатгуулсан малын тоо (мянган толгойгоор, 2006 – 2011 он).....	11
График №8. Хураамжийн орлого, сая төгрөгөөр(даатгалын компани, аймгаар, 2011 он).....	11
Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай,Завхан аймгуудын борлуулалтын үр дүн	
График №9. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо (2010 – 2011 он).....	12
График №10. Хураамжийн орлого (сая төгрөгөөр, 2010 – 2011 он).....	13
График №11. МЭД-д даатгуулсан малын тоо (мянган толгойгоор, 2010 – 2011 он).....	13
Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудын борлуулалтын үр дүн	
График №12. МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоо(даатгалын компани, аймгаар, 2011 он)...	14
График №13. Хураамжийн орлого, сая төгрөгөөр(даатгалын компани, аймгаар, 2011 он).....	14
График №14. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо (2010 – 2011 он).....	15
График №15. МЭД-д даатгуулсан малын тоо (мянган толгойгоор, 2010 – 2011 он).....	16
Даатгалын компаниудын борлуулалтын үр дүн	
График №16. МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоо(даатгалын компани, аймгаар, 2011 он)...	16
График №17. Хураамжийн орлого, сая төгрөгөөр(даатгалын компани, аймгаар, 2011 он).....	17
График №18. Даатгалын компаниудын хураамжийн орлого, дүнд эзлэх хувиар.....	18
График №19. МЭД-ын хураамжийн орлого (аймаг, даатгалын компаниар, 2011 он).....	19
График №20. Борлуулалт хийсэн болон борлуулалт хийгээгүй даатгалын төлөөлөгчдийн тоо (даатгалын компаниар).....	19
График №21. Борлуулалт хийсэн болон огт борлуулалт хийгээгүй төлөөлөгчдийн тоо, аймгаар.....	20
МЭД-ын хураамжийн зээл	
График №22. МЭД-ын хураамжийн зээлийн хэмжээ.....	23



I. МЭД-ын 2011 оны борлуулалтын улиралд хийж гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан МИДТ-ийн “Хөгжлийн зээлийн шинэчилсэн хэлэлцээр”, “Төсөл хэрэгжүүлэх заавар”, ажлын төлөвлөгөөний дагуу МЭД-ын 2011 оны борлуулалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хүснэгт №1. МЭД-ын 2011 борлуулалтын улирлын үйл явц

Огноо	Үйл ажиллагаа
2010 оны 9-12-р сар	- МЭД-ын 2011 оны борлуулалтын улиралд хийх өөрчлөлтүүдийг тодорхойлсон. - Дорнод, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудыг МИД төсөлд шинээр хамрагдуулахаар сонгосон. - Төсөлд шинээр хамрагдсан Дорнод, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудын МЭД-ын хураамжийн хувийг тодорхойлсон. - МИД төслийн програм хангамжийн 2011 оны хувилбарыг боловсруулж эхэлсэн. - МЭД-ын 2011 оны борлуулалтын улиралд оролцох даатгалын компаниудыг сонгон шалгаруулсан ба, 2010 оны борлуулалтын улиралд оролцсон 4 даатгалын компани дахин оролцохоор болсон. 2011 оны борлуулалтын улирал 04-р сарын 15-наас 07-р сарын 15 хүртэлх хугацаанд үргэлжлэхээр тогтов. 2011 оны борлуулалтын төлөвлөгөөг боловсруулсан. - МИД-ын программ хангамжийн 2010 оны хувилбарыг хаан, 2010 оны борлуулалтын мэдээллийн санг битүүмжилсэн. - МЭД-ын 2010 оны нөөцийн сангуудад хүү тооцох гэрээг Төрийн Банк болон Хас Банктай байгуулсан.
2011 оны 1-р сар	МЭД-ын зарчим, үйл ажиллагааны талаарх даатгалын компанийн сургагч багш, сумдын ажилтнууд, даатгалын төлөөлөгчид, орон нутгийн удирдлагуудад зориулсан гарын авлагын мэдээллийг шинэчлэн боловсруулсан.
2-р сар	“Малын эрсдэлийн даатгал” гарын авлагыг боловсруулж, даатгалын төлөөлөгч болон оролцогч талуудад тараасан. - МИД-ын тэргүүний даатгалын төлөөлөгчдийн дунд туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан. 2010 онд МЭД-д хамрагдсан малчдад зориулсан 2011 оны цаг тооны бичгийг бэлдэж хэвлэн малчдад тараасан.
3-р сар	- МЭД-ын гэрээг шинэчлэн боловсруулсан. - МЭД-ын 2011 оны борлуулалтын улиралд ашиглагдах даатгалын баталгааны маягт, гэрчилгээ, дардасын загварыг боловсруулан хэвлэсэн. - МЭД-ын болон ердийн даатгалын төлөөлөгчид эрх олгох шалгалтыг ТХН, СЗХ-ны төлөөлөлтэйгээр зохион байгуулж, 804 төлөөлөгчдөд МЭД-ыг борлуулах эрх олгож, 180 төлөөлөгчийн эрхийг сунган, нийт 984 даатгалын төлөөлөгч 2011 оны МЭД-ын борлуулалтын улиралд ажиллахаар болсон. - Даатгалын хураамжийг цуглуулах МДНТ-ийн дансыг төсөлд шинээр хамрагдсан Дорноговь, Дундговь, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай, Дорнод аймгуудын сумдад шинээр нээж, Хаан банктай байгуулсан “МИД-ын аймаг, сумдын дансуудад үйлчилгээ үзүүлэх гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. - Даатгалын компанийн сургагч багш нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан.
4-р сар	- Оролцогч даатгалын компаниудтай МИД-ын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. - Даатгалын компаниудад баталгаа, гэрчилгээ, дардасыг хүлээлгэн өгч борлуулалтын улирал эхлэх бэлтгэл ажлыг хангасан. - МЭД-ын 2011 оны борлуулалтын улирал эхэлж, даатгалын төлөөлөгчид орон



	нутагт борлуулалтын үйл ажиллагаагаа эхэлсэн. • Зурагт хуудас, нугалбар, даатгагчдад зориулсан товхимол, сонин зэрэг хэвлэмэл сурталчилгааны материалуудыг хэвлэж тараасан. • МЭД-д хамрагдах хүсэлтэй малчдыг богино хугацаанд, түргэн шуурхай хамрагдах боломжийг олгох, даатгалын төлөөлөгчдийн борлуулалтын зардлыг хэмнэх зорилгоор даатгалд хамрагдах хүсэлтэй малчдын санал хүсэлтийг 9100-0770, 98070770 утсаар авч, ТХН-ийн аймгийн салбарууд, даатгалын төлөөлөгчдөд мэдэгдэж, борлуулалтыг эрчимжүүлсэн. • МИД-ын програм хангамжийн 2011 оны хувилбар боловсруулагдсан. • МЭД-ын 2011 оны борлуулалтын улирлыг идэвхижүүлэх, борлуулалтын мэдээллийг чанаржуулах, борлуулалтын явцад ТХН-ийн зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор долоо хоног тутамд борлуулалтын мэдээг явуулж байхыг ТХН-ийн аймгийн салбаруудад үүрэг болгож, борлуулалтын мэдээг оролцогч талуудад цаг тухай бүр бэлтгэн хүргэсэн. • МЭД-ын 2011 оны борлуулалтыг идэвхижүүлэх, борлуулалтын явцтай танилцах зорилгоор ТХН-ийн зүгээс аймгийн зохицуулагч нарыг сумдуудад ажиллуулсан. • ХААН банкны зүгээс олгож буй “МЭД-ын Хураамжийн зээлийн гэрээ”, түүний журам болон “Даатгагдсан малчдад хөнгөлөлт үзүүлэх хамтын ажиллагааны гэрээ”-ний нэмэлт өөрчлөлтөнд гарын үсэг зурсан.
5-р сар	• МЭД-ын 2010 оны борлуулалтанд оролцогч даатгалын компаниуд МИД-д оролцогчийн хураамжийг ТХН-ийн дансанд байршуулсан. • МЭД-ын борлуулалтыг бүртгэх програм хангамжийг төсөл хэрэгжиж буй аймгууд дахь даатгалын компани болон ТХН-д суурилуулж, програм хангамжийн сургалтыг зохион байгуулсан. • Засгийн газрийн хэрэг эрхлэх газраас сумдын Засаг даргын орлогч болон МЭУТМААҮТҮБХМэргэжилтний ажил үүргийн хуваарьт МИД-ыг оруулах албан тоот гарсантай холбогдуулан төсөл хэрэгжиж байгаа 15 аймгийн нийт сумдын ЗДОрлогч болон МЭУТМААҮТҮБХМэргэжилтнүүдэд МИД-ын тухай сургалтыг зохион байгуулсан. • МЭД-ын 2011 борлуулалтыг эрчимжүүлэх зорилгоор ТХН-ийн аймгийн салбарын СССОНХариуцсан ажилтнууд малчин өрхүүдээр орон МИД-ын талаар сургалт, сурталчилгааг хийсэн.
6-р сар	• Хагас жилийн мал тооллогыг түүвэр судалгааны аргаар зохион байгуулах болсонтой холбогдуулан түүвэр судалгааны аргын тухай сургалтыг ҮСХ-той хамтран зохион байгуулсан. • Хагас жилийн мал тооллого түүвэр судалгааны аргаар төсөл хэрэгжиж байгаа 15 аймагт явагдсан.
7-р сар	• 2011 оны хагас жилийн мал тооллого, түүвэр судалгааны дүн мэдээг нэгтгэн боловсруулсан. • 2010 онд МЭД-д даатгуулсан малчдад олгох нөхөн төлбөрийн тооцооллыг төслийн програм хангамж ашиглан хийсэн. • Төсөл хэрэгжиж буй аймгуудад ажиллан МЭД-ын 2011 борлуулалтын улирлыг хаасан. • Орон нутаг дахь даатгалын компаниудын борлуулалтын мэдээллийн санг битүүмжлэн програм хангамжийг хаасан. • МЭД-ын хураамжийн орлогыг татан төвлөрүүлж эхэлсэн.
8-р сар	• 2010 онд МЭД-д хамрагдсан малчдад нөхөн төлбөрийг шилжүүлэх ажил эхэлсэн. • Аймгуудын борлуулалтын мэдээллийн санг татсан.
9-10-р сар	• Оролцогч даатгалын компаниудтай МЭД-ын 2011 оны борлуулалтыг тулгах, МИД-д оролцогчийн хураамжийн бодит хэмжээг тодорхойлох ажил явагдаж байна.




II. МЭД-ын 2011 оны борлуулалт


МИД-ын тавдахь борлуулалтын улирал 2011 оны 4-р сарын 15-нд Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Хэнтий, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Өвөрхангай, Дорноговь, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Ховд аймгийн нийт 251 сумдад эхэлснээс хойш 2011 оны 7-р сарын 15 хүртэлх хугацаанд төсөлд оролцогч Бодь, Монгол, Тэнгэр, Практикал даатгалын компаниуд нийт **10,909 малчинтай** МЭД-ын гэрээг байгуулж, **847 сая төгрөгийн** борлуулалт хийж, **565,3 сая төгрөгийг** МДНТД-нд төвлөрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн 2010 оны МЭД-ын борлуулалттай харьцуулахад борлуулалтын орлого 224,6 сая төгрөг буюу 36.1 хувиар, даатгуулагчдын тоо 3,932 малчин буюу 56.4 хувиар өссөн дүнтэй байна. 2011 оны борлуулалтын улиралд 4 даатгалын компанийн нийт 984 даатгалын төлөөлөгч эрх авсанаас 656 төлөөлөгч идэвхи санаачлагатай ажилласан бол 328 төлөөлөгч МЭД-ын борлуулалт огт хийгээгүй байна. МЭД-ын нийт хураамжийн орлого нь ДНБ-ний 0.01 хувийг эзэлж байна.

Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогыг 2006 оноос хойш харахад тогтмол өссөн хандлагатай байна. График 1,2-т даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогын өсөлтийг харууллаа.

График №1. МИД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо¹



¹ 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.

**График №2. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого /сая төгрөгөөр/²**

Төсөл хэрэгжиж байгаа нийт 15 аймгийн хураамжийн орлого, даатгуулсан малчин өрхийн тоо дараах байдалтай байна.

Хүснэгт №2. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо, хураамжийн хэмжээ, 2011 он

№	Аймгийн нэр	Даатгуулсан малчин өрхийн тоо	Малчны төлсөн хураамж
1	Баянхонгор	2,613	217,361,803
2	Булган	170	10,612,047
3	Говь-Алтай	1,116	91,275,698
4	Дорноговь	378	40,866,571
5	Дорнод	269	32,759,925
6	Дундговь	135	20,085,213
7	Завхан	907	52,029,634
8	Өвөрхангай	128	12,569,358
9	Сүхбаатар	853	96,785,005
10	Сэлэнгэ	310	15,712,992
11	Увс	2,637	128,672,444
12	Ховд	231	28,149,712
13	Хөвсгөл	417	24,090,381
14	Хэнтий	685	66,088,399
15	Дархан-Уул	60	9,945,555
Нийт		10,909	847,004,736

Нийт 15 аймгийн хэмжээнд 847,0 сая төгрөгийн борлуулалт хийсний 60,1 хувийг Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгууд, 21,2 хувийг төсөлд 2010 оноос хамрагдсан Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Завхан, Говь-Алтай аймгууд эзэлж байгаа бол үлдсэн 18,7 хувийг 2011 оноос шинээр төсөлд хамрагдсан Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгууд эзэлж байна. Увс аймагт хамгийн олон буюу 2,637 малчин өрх малаа даатгуулсан нь аймгийн нийт малчин өрхийн 29,4 хувийг эзэлж байгааг


² 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.



График№3-аас харж болно. Харин хамгийн их буюу 217,4 сая төгрөгийн хураамжийг Баянхонгор аймгийн малчид төлсөн нь нийт хураамжийн орлогын 25,6 хувийг бүрдүүлж байна. Даатгалын компаниудын борлуулалтын үр дүнг авч үзвэл нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн 39,8 хувийг Монгол даатгал, 24,7 хувийг Бодь даатгал, 24,1 хувийг Тэнгэр даатгал, 11,4 хувийг Практикал даатгал компаниуд тус тус эзэлжээ.

2011 оны байдлаар төсөл хэрэгжиж буй 15 аймагт нийт 119479 малчин өрх байгаагаас 10,909 өрх буюу 9,13 хувь нь МЭД-д хамрагджээ. Аймаг тус бүрийн малчин өрхөд эзлэх хувийг харуулбал:

График №3. Аймгийн малчин өрхөд МЭД-д даатгуулсан малчин өрхийн эзлэх хувь



Түүнчлэн 15 аймгийн хувьд нийт 1,553,927 толгой мал МЭД-д хамрагдсан нь 15 аймгийн 24.6 сая малын 6.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт №3. МЭД-д хамрагдсан малын тоо(малын төрөл, аймгаар)

№	Аймгийн нэр	Даатгасан малын тоо					Нийт
		Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	
1	Баянхонгор	68,337	272,072	16,642	7,313	240	364,604
2	Булган	7,169	4,973	2,375	930	-	15,447
3	Өвөрхангай	4,747	7,033	274	401	12	12,467
4	Говь-Алтай	26,616	99,329	474	573	757	127,749
5	Дархан-Уул	3,572	3,762	1,110	312	-	8,756
6	Дорноговь	15,549	45,317	3,558	2,066	30	66,520
7	Дорнод	24,484	13,631	4,247	3,713	131	46,206
8	Дундговь	4,625	10,089	512	1,371	32	16,629
9	Завхан	95,727	61,307	1,524	1,489	194	160,241
10	Сүхбаатар	72,760	71,506	16,025	6,781	35	167,107
11	Сэлэнгэ	20,978	18,492	5,614	316	-	45,400
12	Увс	151,097	161,658	7,751	2,045	209	322,760
13	Хөвсгөл	24,742	17,081	4,462	1,543	50	47,878
14	Ховд	13,765	28,685	644	732	189	44,015
15	Хэнтий	40,097	47,257	13,111	7,404	206	108,075
Нийт		574,265	862,192	78,323	36,989	2,085	1,553,854



2011 онд даатгалд хамрагдсан малын 37 хувийг хонин сүрэг, 55,5 хувийг ямаан сүрэг, 5 хувийг адуун сүрэг, 2,4 хувийг үхэр сүрэг, 0,13 хувийг тэмээн сүрэг эзэлж байна.

2010 оны жилийн эцсийн мал тооллогоор Монгол улсын хэмжээнд 2559,4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий мал тоологдсон бөгөөд МИД төсөл хэрэгжиж буй 15 аймгийн малын нийт үнэлгээ нь 1851,2 сая төгрөг болж байна. МЭД-д хамрагдаж буй малчин малынхаа үнэлгээг 1-100 хувь хүртэл өөрөө сонгодог онцлогтой. Малаа даатгуулсан малчдын сонгосон малын үнэлгээ 28,4 тэрбум төгрөг байгаа нь 15 аймгийн малын үнэлгээний 1,5 хувийг эзэлж байна.

Хүснэгт №4-өөс нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо, хураамжийн орлого болон нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн хэмжээг харж болно. 2010 оны нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн 89,258 төгрөг байсан бол 2011 онд 77,666 төгрөг болж буурсан байна. Энэ нь малчдын малаа даатгуулах сонирхол нэмэгдэж байгаа хэдий ч өндөр үнэлгээ сонгож өндөр хураамж төлөх чадвар муу байгааг харуулж байна. Нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүнгээрээ Дундговь аймагт хамгийн өндөр буюу 148,779 төгрөгөөр малаа даатгуулжээ.

Хүснэгт №4. Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо, хураамжийн орлого болон нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн(2011 он, аймгаар)


№	Аймгийн нэр	Борлуулалт хийсэн даатгалын төлөөлөгчдийн тоо	Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж борлуулалтын тоо	Нэг даатгалын төлөөлөгчийн дундаж хураамжийн орлого	Нэг малчины төлсөн дундаж хураамж
1	Баянхонгор	98	27	2,217,942	83,183
2	Булган	16	11	663,253	62,424
3	Говь-Алтай	71	16	1,285,573	81,788
4	Дорноговь	21	18	1,946,027	108,113
5	Дорнод	21	13	1,559,996	121,784
6	Дундговь	22	6	912,964	148,779
7	Завхан	81	11	642,341	57,365
8	Өвөрхангай	30	4	418,979	98,198
9	Сүхбаатар	70	12	1,383,572	113,408
10	Сэлэнгэ	30	10	523,766	50,687
11	Увс	66	40	1,953,673	48,897
12	Ховд	21	11	1,340,462	121,860
13	Хөвсгөл	45	9	535,343	57,771
14	Хэнтий	52	13	1,270,931	96,479
15	Дархан-Уул	11	5	904,141	165,759
Нийт		655	17	1,293,643	77,666



Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгуудын 2011 оны борлуулалтын үр дүн


МИД төсөл анх хэрэгжиж эхэлсэн 2006 оноос төсөлд хамрагдсан Баянхонгор, Увс, Хэнтий аймгууд болон 2009 оноос төсөлд хамрагдсан Сүхбаатар аймгийн хувьд малчид нь МИД төслийн талаар өргөн мэдээлэлтэй төдийгүй малын даатгалын үр шимийг хүртсэн, тэр хэмжээгээрээ ач холбогдлыг ойлгодог болсон нь 2011 оны борлуулалтын үр дүнгээс харагдаж байна. Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгуудад Бодь Даатгал, Монгол Даатгал, Практикал Даатгал, Тэнгэр Даатгал компаниуд борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж нийт 6789 малчин өрхийг даатгалд хамруулсан нь нийт даатгуулагчийн 62,2 хувь, 509,2 сая төгрөгийн борлуулалт хийж 339,9 сая төгрөгийг МДНТД-нд төвлөрүүлсэн нь МЭД-ын 2011 оны борлуулалтын орлогын 60 хувийг бүрдүүлж байна.

График №4. МИД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо (2006 – 2011 он)



Тайлбар: 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоог авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоогоор авсан болно.

График №5. МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоо(даатгалын компани, аймгаар, 2011 он)





Увс аймгийн Өндөрхангай сум 580 малчин өрх, 778 малтай өрхтэй бөгөөд 670 өрх буюу малчин өрх 100 хувь, малтай өрхийн 11,6 хувь нь малаа даатгуулсан нь 2011 онд төсөл хэрэгжсэн 15 аймгийн 251 сумаас хамгийн өндөр хувьтай хамрагдсан байна.


Хүснэгт №5. Даатгуулсан малчин өрхийн тоо ба МДНТД-нд хуримтлуулсан хураамжийн орлогын 2010 оны борлуулалттай харьцуулсан дүн

№	Аймгийн нэр	Даатгуулсан малчин өрх	Малчин өрхөд эзлэх хувь	Борлуулалтын тооны өсөлт	Даатгасан малын тоо	МЭД-ийн дүн	Малчны төлсөн хураамжийн дүн	Хураамжийн дүнгийн өсөлт
1	Баянхонгор	2,613	23.64%	38.8%	364,604	144,911,650	217,361,803	10.4%
2	Увс	2,637	29.42%	50.3%	322,760	85,962,775	128,672,444	53.6%
3	Хэнтий	685	9.82%	-25.8%	108,075	44,438,994	66,088,399	-31.8%
4	Сүхбаатар	853	12.35%	31.6%	167,107	64,523,337	96,785,005	23.8%
		6,788	20.02%	30.3%	962,546	339,836,757	508,907,651	11.6%

Хүснэгтээс харахад Увс аймгийн нийт малчин өрхийн 29,4 хувь нь даатгалд хамрагдсан нь 15 аймгийн хэмжээнд хамгийн өндөр хамрагдалттай байгаа ба өнгөрсөн жил даатгуулсан малчин өрхийн тоотой харьцуулахад 50,3 хувиар өссөн байна. Харин МДНТД-нд төвлөрүүлсэн хураамжийн хэмжээгээрээ Баянхонгор аймгийн малчид 144,9 сая төгрөгийг хуримтлуулсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Сүхбаатар аймагт малаа даатгуулсан малчин өрхийн тоо өнгөрсөн жилийнхээс 31,6 хувиар, хураамжийн хэмжээ 23,8 хувиар өссөн бол Хэнтий аймагт даатгалд хамрагдагсдын тоо болон хураамжийн хэмжээ буурсан дүнтэй байна.

График №6 дээр Баянхонгор, Увс, Сүхбаатар аймгуудын хураамжийн орлогын хэмжээ жил бүр өсөж байгаа нь харагдаж байна. Хэнтий аймгийн хураамжийн орлого, даатгуулсан малчин өрхийн тоо буурсан нь энэ жил зуншлага сайхан байгаагийн дээр тус аймагт нөхөн төлбөрийн тохиолдол гараагүйтэй холбоотой.

График №6. МДНТД-нд төвлөрүүлсэн хураамжийн орлого 2006–2011 он (сая төг.өөр)




2006-2009 оны хураамжийн орлогыг авахдаа ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.

Баянхонгор, Увс, Сүхбаатар, Хэнтий аймгуудад малаа даатгуулсан малчдын сонгосон малын үнэлгээ 15,4 тэрбум төгрөг байгаа нь эдгээр 4 аймгийн малын үнэлгээний 2,92 хувийг эзэлж байна.



Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 364,6 мянган толгой малыг МЭД-д хамруулсан нь хамгийн өндөр буюу аймгийн нийт малтай харьцуулахад 18,6 хувийг эзэлж байна. Мөн даатгуулсан малын үнэлгээ нь 4,2 тэрбум төгрөг буюу аймгийн малын үнэлгээний 3,5 хувийг эзэлж байна.


График №7. МИД-ын бүтээгдэхүүнд хамрагдсан малын тоо (мянган толгойгоор, 2006 – 2011 он)



Тайлбар: 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоог авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоогоор авсан болно.

Тэгвэл тухайн аймгуудад ажиллаж буй даатгалын компанийн салбаруудын даатгалын хураамжийн хэмжээ дараах байдалтай байна.

График №8. Хураамжийн орлого, сая төгрөгөөр(даатгалын компани, аймгаар, 2011 он)





2010 онд МИД төсөлд хамрагдсан Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймгуудын борлуулалтын үр дүн

МИД төслийн туршилтын хугацаа 2009 онд дуусгавар болж үндэсний хэмжээнд хэрэгжихээр болсонтой холбоотойгоор 2010 оноос Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймгуудыг нэмж хамруулсан. Хэдийгээр төсөлд хамрагдаад 2 жил болж байгаа ч эдгээр аймгуудын малчид МИД төслийн талаар багагүй мэдээлэлтэй болж даатгуулах малчин өрхийн тоо цаашид өсөх хандлагатай байгаа нь 2011 оны борлуулалтын үр дүнгээс харагдаж байна. Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймгуудад Бодь Даатгал, Монгол Даатгал, Практикал Даатгал, Тэнгэр Даатгал компаниуд борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж нийт 179,6 сая төгрөгийн борлуулалт хийж 119,7 сая төгрөгийг МДНТД-нд төвлөрүүлсэн нь МЭД-ын 2011 оны борлуулалтын орлогын 21,2 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт №6. Даатгуулсан малчин өрхийн тоо ба МДНТД-нд хуримтлуулсан хураамжийн орлогын 2010 оны борлуулалттай харьцуулсан дүн

№	Аймгийн нэр	Даатгуулсан малчин өрх	Малчин өрхөд эзлэх хувь	Борлуулалтын тооны өсөлт	Даатгасан малын тоо	МЭД-ийн дүн	Малчны төлсөн хураамжийн дүн	Хураамжийн дүнгийн өсөлт
1	Булган	170	2.28%	126.7%	15,447	7,074,698	10,612,047	-20.7%
2	Говь-Алтай	1,116	15.53%	18.1%	127,749	60,850,465	91,275,698	9.7%
3	Завхан	907	10.42%	68.9%	160,241	34,686,423	52,029,634	10.9%
4	Сэлэнгэ	310	7.40%	210.0%	45,400	10,475,328	15,712,992	73.0%
5	Дархан-Уул	60	4.98%	-46.4%	8,756	6,630,370	9,945,555	-32.6%
		2,563	8.92%	44.9%	357,593	119,717,284	179,575,925	7.3%

Хүснэгтээс харахад Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ аймгуудын борлуулалтын орлого болон даатгуулсан малчин өрхийн тоо өссөн дүнтэй байгаа бол Дархан-Уул аймагт буурсан дүнтэй байна. Харин Булган аймгийн борлуулалтын орлого 2010 оныхоос 20,7 хувиар буурсан хэдий ч даатгуулсан малчин өрхийн тоо 126,7 хувиар өссөн дүн харагдаж байна. Энэ нь Булган аймгийн малчдын малаа даатгуулах сонирхол нэмэгдэж байгаа хэдий ч өндөр үнэлгээгээр хураамжаа төлөх чадваргүй байгааг харуулж байна.

График №9. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо (2010 – 2011 он)








График №10. Хураамжийн орлого (сая төгрөгөөр, 2010 – 2011 он)



Графикаас харахад Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ аймгуудын хураамжийн орлогын хэмжээ өссөн дүнтэй, Булган, Дархан-Уул аймгийн хураамжийн орлого буурсан дүнтэй харагдаж байна.

График №11. МЭД-д даатгуулсан малын тоо (мянган толгойгоор, 2010 – 2011 он)



Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймгуудад малаа даатгуулсан малчдын сонгосон малын үнэлгээ 6,8 тэрбум төгрөг байгаа нь эдгээр 5 аймгийн малын үнэлгээний 1,1 хувийг эзэлж байна.



Харин тухайн аймгуудад ажиллаж буй даатгалын компанийн салбаруудын даатгалын хураамжийн хэмжээ, даатгуулсан малчин өрхийн тоо дараах байдалтай байна.

График №12. МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоо(даатгалын компани, аймгаар, 2011 он)





График №13. Хураамжийн орлого, сая төгрөгөөр(даатгалын компани, аймгаар, 2011 он)





2011 онд МИД төсөлд шинээр хамрагдсан Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудын борлуулалтын үр дүн


2011 оноос төслийн хамрах хүрээ улам өргөжин тэлж Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудыг нэмж хамруулснаар нийт 15 аймагт хэрэгжлээ. 2006 оноос эхлэн малаа даатгуулж, даатгалын үр шимийг нь үзсэн малчидтай харьцуулахад шинэ аймгуудын малчид МИД төслийн талаар мэдээлэл бага, малын даатгалд итгэх итгэл муутай байгаа нь 2011 оны борлуулалтын үр дүнгээс харагдаж байна. Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудад Бодь Даатгал, Монгол Даатгал, Практикал Даатгал, Тэнгэр Даатгал компаниудын 15 салбар нэгж борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж нийт 158,5 сая төгрөгийн борлуулалт хийж 105,7 сая төгрөгийг МДНТД-нд төвлөрүүлсэн нь МЭД-ын 2011 оны борлуулалтын орлогын 18,7 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт №7. Даатгуулагчдын тоо ба МДНТД-нд хуримтлуулсан хураамжийн орлогын дүнд эзлэх хувь

№	Аймгийн нэр	Даатгуулсан малчин өрх	Малчин өрхөд эзлэх хувь	Даатгасан малын тоо	МЭД-ийн дүн	Малчны төлсөн хураамжийн дүн
1	Дорноговь	378	11.13%	66,520	27,244,409	40,866,571
2	Дорнод	269	6.62%	46,206	21,839,950	32,759,925
3	Дундговь	135	2.16%	16,629	13,390,142	20,085,213
4	Өвөрхангай	128	0.82%	12,467	8,379,572	12,569,358
5	Ховд	231	2.72%	44,015	18,766,475	28,149,712
6	Хөвсгөл	417	2.59%	47,878	16,080,774	24,090,381
		1,558	2.89%	233,715	105,701,321	158,521,160

Шинээр төсөлд хамрагдсан 6 аймгаас Дорноговь аймагт 378 малчин өрх даатгалд хамрагдсан нь аймгийн малчин өрхөд эзлэх хамгийн өндөр хувь буюу 11,1 хувийг эзэлж байна.

График №14. МЭД-д даатгуулсан малчин өрхийн тоо (2010 – 2011 он)





Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудад малаа даатгуулсан малчдын сонгосон малын үнэлгээ 6,2 тэрбум төгрөг байгаа нь эдгээр 6 аймгийн малын үнэлгээний 0,9 хувийг эзэлж байна.

График №15. МЭД-д даатгуулсан малын тоо (мянган толгойгоор, 2010 – 2011 он)



Харин тухайн аймгуудад ажиллаж буй даатгалын компанийн салбаруудын даатгалд хамруулсан малчин өрхийн тоо, даатгалын хураамжийн хэмжээ дараах байдалтай байна.

График №16. МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоо(даатгалын компани, аймгаар, 2011 он)







График №17. Хураамжийн орлого, сая төгрөгөөр(даатгалын компани, аймгаар, 2011 он)





III. Даатгалын компани

2011 оны борлуулалтын улиралд төсөл хэрэгжиж буй 15 аймагт нийт 984 даатгалын төлөөлөгч МЭД-ыг борлуулах эрх авснаас нийт 655 төлөөлөгч /Бодь Даатгал компани 148, Монгол Даатгал компани 259, Тэнгэр Даатгал компани 144, Практикал Даатгал компани 104 борлуулалт хийж үр бүтээлтэй ажилласан бол 329 даатгалын төлөөлөгч огт борлуулалт хийгээгүй байна.

МИД-ын 2010 оны борлуулалтын орлогын хэмжээг оролцогч даатгалын компани тус бүрээр харуулбал:

Хүснэгт №8. Даатгалын компаниудын борлуулалтын тоо, хураамжийн орлогын дүн (аймаг, даатгалын компаниар, 2011 он)

Компани		Монгол даатгал		Бодь даатгал		Тэнгэр даатгал		Практикал даатгал		Нийт	
№	Аймгийн нэр	Малчин өрх	Малчны төлсөн хураамж	Малчин өрх	Малчны төлсөн хураамж	Малчин өрх	Малчны төлсөн хураамж	Малчин өрх	Малчны төлсөн хураамж	Малчин өрх	Малчны төлсөн хураамж
1	Баянхонгор	1,089	90,915,199	761	68,656,773	413	32,843,920	350	24,945,910	2,613	217,361,803
2	Булган	99	5,863,422	71	4,748,625					170	10,612,047
3	Говь-Алтай	508	43,359,832	236	24,691,810	255	15,551,115	117	7,672,940	1,116	91,275,698
4	Дорноговь	165	18,826,475	213	22,040,096					378	40,866,571
5	Дорнод	46	8,808,041			223	23,951,884			269	32,759,925
6	Дундговь	135	20,085,213							135	20,085,213
7	Завхан	372	21,777,841	284	17,282,788	198	10,706,381	53	2,262,624	907	52,029,634
8	Өвөрхангай	51	5,352,117			65	5,593,206	12	1,624,035	128	12,569,358
9	Сүхбаатар	418	54,930,369	172	19,703,579	197	16,160,325	66	5,990,732	853	96,785,005
10	Сэлэнгэ	151	6,017,877	159	9,695,115					310	15,712,992
11	Увс	854	40,092,923	569	30,062,935	754	36,912,326	460	21,604,260	2,637	128,672,444
12	Ховд	166	17,365,785			59	9,802,862	6	981,065	231	28,149,712
13	Хөвсгөл	112	7,312,603	95	5,504,707	106	6,844,128	104	4,428,943	417	24,090,381
14	Хэнтий	157	20,166,818	101	12,412,129	359	27,060,684	68	6,448,768	685	66,088,399
15	Дархан-Уул	25	3,513,660	35	6,431,895					60	9,945,555
Нийт		4,348	364,388,176	2,696	221,230,450	2,629	185,426,832	1,236	75,959,278	10,909	847,004,736

2011 оны борлуулалтаар нийт 847 сая төгрөгний борлуулалт хийсний 43 хувийг Монгол Даатгал, 26,1 хувийг Бодь даатгал, 21,9 хувийг Тэнгэр Даатгал, 9 хувийг Практикал Даатгал компани тус тус эзэлж байна. Харин нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн 39,8 хувийг Монгол даатгал, 24,7 хувийг Бодь даатгал, 24,1 хувийг Тэнгэр даатгал, 11,4 хувийг Практикал даатгал компаниуд тус тус эзэлжээ.

График №18. Даатгалын компаниудын хураамжийн орлого, дүнд эзлэх хувиар








График №19. МЭД-ын хураамжийн орлого (аймаг, даатгалын компаниар, 2011 он)



Хүснэгт №9. Даатгуулагчдын тоо ба хураамжийн орлогын 2010 оны борлуулалттай харьцуулсан дүн (даатгалын компаниар)

№	Компани	Даатгасан малчин өрх	Өсөлтийн хувь	Хураамжийн орлого	Өсөлтийн хувь
1	Монгол даатгал	4348	64.4%	364,388,175.93₮	44.4%
2	Бодь даатгал	2696	55.2%	221,230,450.46₮	27.4%
3	Тэнгэр даатгал	2629	55.7%	185,426,832.08₮	43.5%
4	Практикал даатгал	1236	36.3%	75,959,277.55₮	12.5%
Нийт		10909	56.4%	847,004,736.02₮	36.0%

График №20. Борлуулалт хийсэн болон борлуулалт хийгээгүй даатгалын төлөөлөгчдийн тоо (даатгалын компаниар)






Даатгалын компаниудын нийт дүнгээр 655 даатгалын төлөөлөгч ямар нэг хэмжээгээр борлуулалт хийсэн бол 329 төлөөлөгч огт борлуулалт хийгээгүй байна. Харин аймаг тус бүрээр нь борлуулалт хийсэн болон огт борлуулалт хийгээгүй төлөөлөгчдийн тоог харуулбал:

Хүснэгт №10. Борлуулалт хийсэн болон огт борлуулалт хийгээгүй төлөөлөгчдийн тоо (аймаг, даатгалын компаниар)

№	Компани Аймгийн нэр	Монгол даатгал		Бодь даатгал		Тэнгэр даатгал		Практикал даатгал		Нийт	
		Борлуулалт хийсэн	Борлуулалт хийгээгүй	Борлуулалт хийсэн	Борлуулалт хийгээгүй	Борлуулалт хийсэн	Борлуулалт хийгээгүй	Борлуулалт хийсэн	Борлуулалт хийгээгүй	Борлуулалт хийсэн	Борлуулалт хийгээгүй
1	Баянхонгор	33	4	23	2	23	2	19	7	98	15
2	Булган	10	9	6	7					16	16
3	Говь-Алтай	27	12	14	3	19	5	11	7	71	27
4	Дорноговь	12	6	9	3					21	9
5	Дорнод	9	21			12	2			21	23
6	Дундговь	22	11							22	11
7	Завхан	27	7	23	7	20	7	11	12	81	33
8	Өвөрхангай	14	13			10	9	6	14	30	36
9	Сүхбаатар	27	6	15	7	12	3	16	3	70	19
10	Сэлэнгэ	18	5	12	8					30	13
11	Увс	18	4	18	4	14	3	16	4	66	15
12	Ховд	11	16			7	10	3	12	21	38
13	Хөвсгөл	14	16	10	8	10	14	11	14	45	52
14	Хэнтий	12	1	12	3	17	3	11	8	52	15
15	Дархан-Уул	5	0	6	4		3			11	7
	Нийт	259	131	148	56	144	61	104	81	655	329

График №21. Борлуулалт хийсэн болон огт борлуулалт хийгээгүй төлөөлөгчдийн тоо, аймгаар





МЭД-д хамрагдсан малчин өрхийн тоог даатгалын компани тус бүрээр харуулбал:

Хүснэгт №11. Даатгалын компаниудын даатгуулагчдын тоо, дүнд эзлэх хувиар

Компани		Монгол даатгал		Бодь даатгал		Тэнгэр даатгал		Практикал даатгал		Нийт	
№	Аймгийн нэр	Малчин өрх	Хувь	Малчин өрх	Хувь	Малчин өрх	Хувь	Малчин өрх	Хувь	Малчин өрх	Хувь
1	Баянхонгор	1,089	42%	761	29%	413	16%	350	13%	2,613	24%
2	Булган	99	58%	71	42%					170	2%
3	Говь-Алтай	508	46%	236	21%	255	23%	117	10%	1,116	10%
4	Дорноговь	165	44%	213	56%					378	3%
5	Дорнод	46	17%			223	83%			269	2%
6	Дундговь	135	100%							135	1%
7	Завхан	372	41%	284	31%	198	22%	53	6%	907	8%
8	Өвөрхангай	51	40%			65	51%	12	9%	128	1%
9	Сүхбаатар	418	49%	172	20%	197	23%	66	8%	853	8%
10	Сэлэнгэ	151	49%	159	51%					310	3%
11	Увс	854	32%	569	22%	754	29%	460	17%	2,637	24%
12	Ховд	166	72%			59	26%	6	3%	231	2%
13	Хөвсгөл	112	27%	95	23%	106	25%	104	25%	417	4%
14	Хэнтий	157	23%	101	15%	359	52%	68	10%	685	6%
15	Дархан-Уул	25	42%	35	58%					60	1%
Нийт		4,348	40%	2,696	25%	2,629	24%	1,236	11%	10,909	100%

**IV. МЭД-ын хураамжийн зээл**

МЭД-ын хураамжийн зээлийг Хаан банктай хамтран 2011 оны 4 дүгээр сарын 15-аас 7 дугаар сарын 15-ны хооронд төсөл хэрэгжиж буй 15 аймгийн /Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар, Говь-Алтай, Завхан, Увс, Баянхонгор, Дорнод, Дорноговь, Дундговь, Ховд, Хөвсгөл, Өвөрхангай/ нийт 251 сумдын Хаан банкны орон нутгийн салбаруудаар дамжуулан нийт 50 малчинд 8,968,425.00 төгрөгийн МЭД-ын хураамжийн зээлийг олголоо.


Хүснэгт №12. МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо

№	Аймаг	МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо	Хаан банкнаас авсан зээлийн хэмжээ	МЭД-ын эрсдэл тооцсон хураамж	Даатгалын компанийн үйл ажиллагааны зардал
1	Баянхонгор	3	309,565	206,377	103,188
2	Увс	1	88,500	59,000	29,500
3	Хэнтий	23	4,519,503	3,013,002	1,506,501
4	Сүхбаатар	1	320,400	213,600	106,800
5	Булган	2	287,750	191,833	95,917
6	Сэлэнгэ	3	495,000	330,000	165,000
7	Дорноговь	2	441,408	294,272	147,136
8	Дорнод	10	1,305,101	870,067	435,034
9	Дундговь	5	1,201,198	800,799	400,399
Нийт		50	8,968,425	5,978,950	2,989,475

ХААН банкнаас олгож буй энэхүү зээлийг өнгөрсөн жил Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Говь-Алтай, Завхан аймгуудад олгосон бөгөөд эдгээр аймгуудын МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо, хураамжийн зээлийн хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад зээл авсан малчдын тоо 81 хувиар, хураамжийн зээлийн хэмжээ 71 хувиар буурсан байна.

Хүснэгт №13. МЭД-ын хураамжийн зээлийн хэмжээ

№	Аймаг	2009		2010		2011	
		МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо	Хаан банкнаас авсан зээлийн хэмжээ	МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо	Хаан банкнаас авсан зээлийн хэмжээ	МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо	Хаан банкнаас авсан зээлийн хэмжээ
1	Баянхонгор	53	4,782,395	8	1,078,540	3	309,565
2	Увс	7	391,446	3	201,780	1	88,500
3	Хэнтий	78	7,423,464	104	16,954,168	23	4,519,503
4	Сүхбаатар	4	95,438	24	3,502,239	1	320,400
5	Завхан	-	-	10	1,387,032	-	-
6	Говь-Алтай	-	-	12	2,214,850	-	-
7	Булган	-	-	8	1,457,125	2	287,750
8	Сэлэнгэ	-	-	26	3,934,455	3	495,000
9	Дорноговь	-	-	-	-	2	441,408
10	Дорнод	-	-	-	-	10	1,305,101
11	Дундговь	-	-	-	-	5	1,201,198
12	Дархан-Уул	-	-	2	257,250	-	-
Нийт		142	12,692,743	197	30,987,439	50	8,968,425

**График №22. МЭД-ын хураамжийн зээлийн хэмжээ**

Малчдын ХААН банкнаас авч байгаа МЭД-ын хураамжийн зээлийн дунджийг 2011 онд хураамжийн зээл авсан малчидтай 9 аймгийн хэмжээнд тооцоолбол 179,368.50 төгрөг байна.

Хүснэгт №14. МЭД-ын хураамжийн зээлийн дундаж

№	Аймаг	МЭД-ын хураамжийн зээлийн дундаж
1	Баянхонгор	103,188.3₮
2	Увс	88,500.0₮
3	Хэнтий	196,500.1₮
4	Сүхбаатар	320,400.0₮
5	Булган	143,875.0₮
6	Сэлэнгэ	165,000.0₮
7	Дорноговь	220,704.0₮
8	Дорнод	130,510.1₮
9	Дундговь	240,239.6₮
Нийт		179,368.5₮

ТХН-ийн зүгээс МЭД-ын хураамжийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтийг ХААН банкинд тавьсан бөгөөд Хаан банк зээлийн хэмжээг 400,000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Малчдын хувьд өндөр үнэлгээтэй даатгуулах сонирхолтой байгаа тул дундаж хураамжийн зээлийн хэмжээ өмнөх оныхоос өссөн. Борлуулалтын явцад Хаан банкны ажилчдын хувьд МЭД болон хураамжийн зээлийн талаарх мэдлэг багатай байгаа тул малчид зээл авахад хүндрэл учирч байгаа нь харагдсан. Мөн түүнчлэн хөдөө орон нутагт малчны зээлтэй малчдын тоо өндөр байгаа учир МЭД-ын хураамжийн зээл авсан малчдын тоо бага байна.

Хаан банктай хийсэн гэрээний дагуу малаа даатгуулсан малчин бүр малчны зээлд хамрагдвал тухайн суманд мөрдөгдөж байгаа зээлийн хүүнээс 0,02 нэгжээр бага хүүтэй олгодог. Үүний дагуу ХААН банкнаас 10 дугаар сарын 31-ны байдлаар 2011 онд малаа даатгуулсан 753 малчинд нийт 1,4 тэрбум төгрөгийн зээл олгож хөнгөлөлт үзүүлсэн байна.



Дүгнэлт

МИД-ын 2011 оны борлуулалтын тайланг борлуулалтын улиралд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, төсөлд хамрагдсан хуучин болон шинэ аймгуудын борлуулалтын үр дүн, даатгалын компаниудын борлуулалтын үр дүнгээр авч үзсэн. 2011 оны борлуулалтын улирлаар нийт 847 сая төгрөгийн борлуулалт хийж, 565,3 сая төгрөгийг Малын даатгалын нөхөн төлбөрийн дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн 2010 оны МЭД-ын борлуулалттай харьцуулахад борлуулалтын орлого 224,6 сая төгрөг буюу 36.1 хувиар, даатгуулагчдын тоо 3,932 малчин буюу 56.4 хувиар өссөн дүнтэй байна. МЭД-ын нийт хураамжийн орлого нь ДНБ-ний 0,01 хувийг эзэлж байна. Хураамжийн орлого, даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо жил бүр тогтмол өсч байгаа нь малчид, даатгалын компани энэхүү даатгалыг худалдан авах сонирхолтой байгаа төдийгүй цаашид малын индексжүүлсэн даатгал тогтвортой оршин тогтнохын нэгэн баталгаа болж байгааг харуулж байна.

Төсөлд хамрагдаж байсан хуучин аймгууд болох Баянхонгор, Увс, Хэнтий, Сүхбаатар аймгийн хувьд 6788 малчин өрхийг даатгалд хамруулсан нь нийт даатгуулагчийн 62,2 хувь, 508,9 сая төгрөгийн борлуулалт хийж 339,9 сая төгрөгийг МДНТД-нд төвлөрүүлсэн нь МЭД-ын 2011 оны борлуулалтын орлогын 60 хувийг бүрдүүлж байна.

2010 оноос төсөлд хамрагдсан Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан аймгуудад нийт 2,563 малчин өрх малаа даатгуулсан нь өнгөрсөн оны борлуулалттай харьцуулахад 44,9 хувиар өссөн дүнтэй байгаа ба 2011 оны нийт даатгуулсан өрхийн 23,5 хувийг эзэлж байна. Харин хураамжийн орлогын хувьд 179,6 сая төгрөгийн борлуулалт хийж 119,7 сая төгрөгийг МДНТД-нд төвлөрүүлсэн нь МЭД-ын 2011 оны борлуулалтын орлогын 21,2 хувийг бүрдүүлж байна.

Харин шинээр төсөлд хамрагдаж буй Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл аймгуудад 1558 малчин өрх малаа даатгуулсан нь даатгуулсан малчин өрхийн 14,3 хувийг, 158,7 сая төгрөгийн борлуулалт хийгдэж 105,5 сая төгрөгийг МДНТД-нд төвлөрүүлсэн нь МЭД-ын 2011 оны борлуулалтын орлогын 18,7 хувийг бүрдүүлж байна.

Өмнө нь төсөлд хамрагдаж байсан аймгуудын хувьд малчид нь МИД төслийн талаар өргөн мэдээлэлтэй төдийгүй малын даатгалын үр шимийг хүртсэн, тэр хэмжээгээрээ ач холбогдлыг ойлгодог болсон бол 2011 оноос төсөлд хамрагдсан шинэ аймгуудын малчид МИД төслийн талаар мэдээлэл бага, малын даатгалд итгэх итгэл муутай байгаа нь 2011 оны борлуулалтын үр дүнгээс харагдаж байна. Мөн шинэ аймгуудад даатгалын компанийн салбар нэгжийн тоо цөөн, боловсон хүчин болон даатгалын төлөөлөгчийн чадвар дутмаг байгаа нь борлуулалтын явцад харагдаж байсан юм.

2011 оны борлуулалтын орлогын 43 хувийг Монгол Даатгал, 26,1 хувийг Бодь даатгал, 21,9 хувийг Тэнгэр Даатгал, 9 хувийг Практикал Даатгал компани тус тус эзэлж байна. Харин нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн 39,8 хувийг Монгол даатгал, 24,7 хувийг Бодь даатгал, 24,1 хувийг Тэнгэр даатгал, 11,4 хувийг Практикал даатгал компаниуд тус тус эзэлжээ.

Зарим аймгийн борлуулалтын орлого 2010 оныхоос буурсан хэдий ч даатгуулсан малчин өрхийн тоо өссөн, эсвэл борлуулалтын орлого нь маш бага өссөн байхад даатгуулсан малчин өрхийн тоо их хэмжээгээр өссөн дүн харагдаж байна. Энэ нь малчдын малаа даатгуулах сонирхол нэмэгдэж байгаа хэдий ч өндөр үнэлгээгээр хураамжаа төлөх чадваргүй байгааг харуулж байна. Даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо болон хураамжийн хэмжээний өсөлт нь хоорондоо сул хамааралтай байна. 2010 оны нэг малчин өрхийн төлсөн дундаж хураамжийн дүн 89,258 төгрөг байсан бол 2011 онд 77,666 төгрөг болж буурсан байна.



Төсөл хэрэгжиж байгаа 15 аймгийн хувьд нийт 1,553,854 толгой мал МЭД-д хамрагдсан нь 15 аймгийн 24.6 сая малын 6.3 хувийг эзэлж байна. Малаа даатгуулсан малчдын сонгосон малын үнэлгээ 28,4 тэрбум төгрөг байгаа нь нийт малын үнэлгээний 1,1 хувь, 15 аймгийн малын үнэлгээний 1,5 хувийг эзэлж байна.